

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА
Н.ЧИНБАТ ТАНАА

2021 оны 4 дүгээр сарын 15 ны өдөр

Мэдэгдэл

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт өмнө нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан иргэнийг бүртгэхгүй байх шаардлагыг орхигдуулан хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэхийг 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр хянан хэлэлцэхээр Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг зарлаж, бүрэлдэхүүнд нь таныг оруулсан байна гэж Цэцийн гишүүний туслах надад амаар мэдэгдэж материалыг ирүүллээ.

Энэ талаарх Үндсэн хуулийн цэцийн даргын шийдвэрийг надад танилцуулахаас татгалзсан тул тус хуралдаанд Цэцийн гишүүдээс хэн хэн оролцохыг мэдэх боломжгүй байгаа тул энэхүү мэдэгдлийг Цэцийн бүх гишүүдэд хүргүүлж байгаа болно.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн миний бие дээрх маргааныг Цэцийн дунд суудлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шилжүүлэх тухай Цэцийн гишүүний 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоол Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн холбогдох заалтыг дараах үндэслэлээр зөрчсөн гэж үзэж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт өмнө нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан иргэнийг бүртгэхгүй байх шаардлагыг орхигдуулан хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх талаарх мэдээлэл ирүүлснийг хүлээн авсан Үндсэн хуулийн цэцийн гишүүн үндэслэлтэй гэж үзэж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн тогтоолыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдаанаар хянан шийдвэрлүүлэхийг хүссэн Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Буяндэлгэрийн хүсэлтийг Үндсэн хуулийн Цэцийн дарга Н.Чинбат хүлээн авч тухайн үед Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан Ш Цогтоод хуваарилсан.

Улмаар Цэцийн гишүүн Ш.Цогтоо эл асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдаанаар 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдөр хэлэлцүүлэхээр

шилжүүлсний дагуу Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Чинбат Цэцийн гишүүн Д.Одбаяр, Ц.Нанзаддорж, Ш.Цогтоо нарыг уг хуралдааны бүрэлдэхүүнд оруулан, хуралдаан даргалагчаар Д.Одбаярыг томилсон.

Хуралдаан даргалагч гишүүн Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдааныг даргалах явцдаа элдэв хууль бус шаардлага тавьж, хурлыг ажлын 2 өдөр дараалан саатуулсан бөгөөд сүүлдээ Цэцийн хуралдааныг орхин гарч явсан. Бага суудлын хуралдааны нарийн бичгийн даргад аудио бичлэг хийн, хурал дээр яригдсан бүх яриаг үг үсэг гээлгүй тэмдэглэх үүрэг өгөгдсөн бөгөөд уг тэмдэглэл байгаа болно.


Бага суудлын хуралдааны шийдвэр албаны хэвлэмэл хуудсан дээр бичигдэж, гишүүдийн гарын үсэг зурагдан хадгалагдаж буй тул Цэцийн гишүүд танилцах боломжтой гэж үзэж болсон үйл явцын талаар нуршилгүй орхиж байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр цэцийн хуралдаанаас татгалзан гарах саналаа хуулийн дагуу тавиагүй атлаа хуралдааныг орхин гарч явсан нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг тасралтгүй явуулах шаардлагыг зөрчсөн гэж үзэж хуралдааныг орхин гарсан гишүүнийг оролцооноор тооцож хуралдаанд оролцогч бусад гишүүд хурлыг тасралтгүй үргэлжлүүлэн, хуулийн дагуу шийдвэрээ гаргаж, гарын үсгээ зурсан. Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр Цэцийн хуралдааны шийдвэрт гарын үсэг зурж албажуулах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ үүргээ өнөөг хүртэл биелүүлээгүй байгаа болно.

Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр хуралдахаар зарлагдсан дунд суудлын хуралдаанаар хянан шийдвэрлэх асуудлаар Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдаан нэгэнтээ шийдвэрээ гаргасан, гацхүү энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангах шаардлагатай гэж үзэж байна.

Иймд Цэцийн гишүүний 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоолын дагуу зарлагдсан Цэцийн дунд суудлын хуралдааныг хууль бус гэж үзэж байгаа тул тус хуралдаанд оролцох боломжгүй байгаагаа үүгээр уламжилж байна.

Хувийг, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.СОЛОНГО, Д.ОДБАЯР, Ш.СОЛОНГО, Г.ТУУЛХҮҮ, Б.БУЯНДЭЛГЭР, Г.БАЯСГАЛАН, Ж.ЭРДЭНЭБУЛГАН танаа

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ГИШҮҮН  Ц.НАНЗАДДОРЖ